35	Соёлын төв	14,319.8	13,956.6	(363.2)
35	Сум хөгжүүлэх сан	190,420.0	190,420.0	-
35	Сургууль	92,223.6	83,054.2	(9,169.4)
35	Хүн эмнэлэг	24,837.0	30,494.7	5,657.7
35	Цэцэрлэг	32,310.8	29,664.3	(2,646.5)
	Нийт	380,311.3	379,002.8	(1,308.5)

Сум хөгжүүлэх сангийн данс бүртгэлд малжуулах төслийн хүрээнд анх ОНХС-аас 2013-2014 онд 150420.0 мянга төгрөгөөр 30 айл өрхийг, СХС-аас 2013 онд 40000.0 мянган төгрөгөөр 8 айл өрх, нийт 38 айл өрхийг тус бүр 5000.0 мянган төгрөгөөр буюу 190420.0 мянган төгрөгөөр малжуулсныг данс бүртгэлд тусгажээ.

Хүснэгт № 7. Бараа материал дансны өөрчлөлт: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага, төсөл сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Нэгтгэсэн нийт дүн
1	Оны эхний үлдэгдэл	380,075.2	236.0	380,311.2
2	Нэмэгдсэн	207,066.7	3,138.1	210,204.8
201	Худалдан авсан	187,477.2	3,138.1	190,615.3
202	Хандиваар	15,719.0	0.0	15,719.0
203	Шилжүүлэн авсан	30.0	0.0	30.0
205	Бусад	3,840.5	0.0	3,840.5
3	Хасагдсан	209,091.2	2,422.1	211,513.3
301	Худалдсан, зарцуулсан	197,503.2	2,422.1	199,925.3
302	Шилжүүлсэн	2,435.0	0.0	2,435.0
303	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	143.4	0.0	143.4
304	Бусад	9,009.7	0.0	9,009.7
4	Эцсийн үлдэгдэл	378,050.8	952.0	379,002.8

Алтай сумын ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь тайлан хугацаанд 190615.3 төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, ЕБС 3840.5 мянга, эрүүл мэндийн төв 15658.9 мянга, хүүхдийн цэцэрлэг 90.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 199925.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, 11588.1 мянган төгрөгийн материалыг данс бүртгэлд залруулах болон тохируулгаар бүртгэжээ.

Аудитын илрүүлэлт:

-ЗДТГ, Эрүүл мэндийн төв: Жолоочийн тооцооны хуудас бичигдээгүй, тооцоо бодоогүй, иж бүрдэл дутуу замын хуудсаар тооцоо бодсон, спидометрийн заалт бичээгүй шатахуун зарцуулсан,

-Эрүүл мэндийн төв: Дуудлагын бүртгэлийн журнал, жолоочийн тооцооны хуудсаар бичигдсэн шатахуун нь нярвын тайлангаар зардлагадсан шатахууны бүртгэлтэй зөрүүтэй, эмийн нэр төрлийн тооллого хийгээгүй, тооцоо бодож баримтжуулаагүй, эмийн зарлагын дарааллыг баримтлаагүй, өмнөх оноос эмийн үлдэгдэл их хэмжээгээр өссөн, мал амьтдыг зах зээлийн үнэлгээгээр үнэлж данс бүртгэлд тусгаагүй, ашиг шим, нас дэвшилтийн тооцоо хийгээгүй

Дээрх алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 7087194.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 12134666.1 мянган төгрөг болж, 5047471.5 мянган төгрөгөөр өсчээ.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгө дансны өөлчлөлт:

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага	ТӨҮГ болон ОНӨҮГ	Нэгтгэсэн нийт дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	7,084,944.6	2,250.0	7,087,194.6
2	Нэмэгдсэн	5,047,471.5	-	5,047,471.5
201	Худалдан авсан	20,628.8	-	20,628.8
205	Бусад	5,026,842.6	-	5,026,842.6
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	12,132,416.1	2,250.0	12,134,666.1
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	(1,308,740.8)	(450.0)	(1,309,190.8)
8	Элэгдлийн зардал	278,283.9	450.0	278,733.9
10	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЛИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	(1,587,024.7)	(900.0)	(1,587,924.7)
11	ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ	10,545,391.4	1,350.0	10,546,741.4

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 20628.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 5026842.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийг байгууллагаар ангилбал

/мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
39	Алтай шим ус	1,800.0	1,350.0	-450.0
39	Хо. Ал. Засаг даргын тамгын газар	1,968,090.5	3,556,209.1	1,588,118.6
39	Хо. Ал. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	581.5	1,812.6	1,231.1
39	Хо. Ал. Соёлын төв	595,541.3	608,256.6	12,715.3
39	Хо. Ал. Сургууль	2,420,479.7	5,416,427.4	2,995,947.7
39	Хо. Ал. Хүн эмнэлэг	363,129.4	383,822.9	20,693.5
39	Хо. Ал. Цэцэрлэг	428,381.4	578,862.8	150,481.4
	Нийт	5,778,003.8	10,546,741.4	4,768,737.6

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төв нь эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож данс бүртгэлд тусгаагүй,

түүнчлэн ЕБС зарим эд хөрөнгийг багцалсан бөөн дүнгээр, тодорхойгүй нэршилээр данс бүртгэлд тусгасан,

- ЗДТГ, Эрүүл мэндийн төв: Элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын жил дахин тодорхойлж, үнэлгээ хийгээгүй,

-Соёлын төв: Эд хариуцагчаар хөрөнгийн тооцоо бодож актаар баталгаажуулаагүй байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 1273,5 мянган төгрөг байсан бол оны эцэст 18,3 мянган төгрөг болж, 1255,2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 10. Өр төлбөр дансны үлдэгдлийг байгууллагаар харуулбал: /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
41	Алтай шим ус	358.2	0	-358.2
41	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	235	18.3	-216.7
41	Цэцэрлэг	680.4	0	-680.4
	Нийт	1,273.50	18.3	-1255.2

Хүснэгт № 11. Өр төлбөр дансны ангилал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгах бичилт	Нэгтгэсэн нийт дүн
41	Эхний үлдэгдлийн дүн	915.4	15396.8	358.2	15396.8	1273.5
41	Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	18.3	16069.8	0.0	16069.8	18.3
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	18.3	0.0	0.0	0.0	18.3
41360	Бусад өглөг	0.0	16069.8	0.0	16069.8	0.0

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7902662.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8012879.4 мянган төгрөг болж, 104489.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Цэвэр хөрөнгө, өмчийн байдал: /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,826,426.0	11,303,549.3	4,477,123.3
51100	/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,099,020.2	4,099,020.2	0.0
51210	Өмнөх үеийн үр дүн	453,646.4	545,860.6	92,214.1
51220	Тайлант үеийн үр дүн	101,339.3	4,486,248.5	4,384,909.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,172,419.9	2,172,419.9	0.0

Засгийн газрын сан, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өөрчлөлт ороогүй ба өмнөх үеийн үр дүн 9125.2 мянган төгрөгөөр буурсан нь сум хөгжүүлэх сан, ЕБС-ийн санхүүгийн тайланд тухайн дүнгээр өмнөх оны бүртгэлийн алдааны залруулга хийгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант хугацааны үр дүн 4384909.1 мянган төгрөгөөр өссөний дийлэнх нь хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүйгээр хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Хүснэгт № 13 Цэвэр хөрөнгө өмчийн дүнг төсвийн захирагчдаар ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага, төсөл сан	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Нэгтгэсэн нийт дүн
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,772,158.4	44,871.0	9,396.6	6,826,426.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,125.2	0.0	0.0	-9,125.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,763,033.2	44,871.0	9,396.6	6,817,300.8
19	Тайлант үеийн үр дүн	4,490,113.4	827.4	-4,692.3	4,486,248.5
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,253,146.6	45,698.4	4,704.3	11,303,549.3

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 4055925.0 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна.

Хүснэгт № 14 Орлогыг нэр төрлөөр ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,280,625.2	7,336,550.2	4,055,925.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	83,668.5	90,095.2	6,426.7
110	Орлогын албан татвар	49,983.3	72,860.7	22,877.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	49,983.3	72,860.7	22,877.4
113	Хөрөнгийн албан татвар	3,509.0	2,765.0	-744.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	30,176.3	14,469.5	-15,706.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	287,376.6	4,498,800.9	4,211,424.3
120	Нийтлэг татварын бус орлого	287,376.6	4,498,800.9	4,211,424.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,909,580.1	2,747,654.1	-161,926.0

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь татварын бус орлогод хамаарах үнэ төлбөргүй 4488477.6 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан нь гол нөлөө үзүүлжээ.

Хүснэгт № 15 Орлогыг ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгах бичилт	Нэгтгэсэн нийт дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,901,407.6	728,995.7	-4,242.3	1,289,610.8	7,336,550.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	90,095.2	0.0	0.0	90,095.2
110	Орлогын албан татвар	0.0	72,860.7	0.0	0.0	72,860.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.0	72,860.7	0.0	0.0	72,860.7
113	Хөрөнгийн албан татвар	0.0	2,765.0	0.0	0.0	2,765.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	0.0	14,469.5	0.0	0.0	14,469.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,055,699.6	5,298.1	-4,242.3	557,954.6	4,498,800.9
120	Нийтлэг татварын бус орлого	5,055,699.6	5,298.1	-4,242.3	557,954.6	4,498,800.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,845,708.0	633,602.4	0.0	731,656.3	2,747,654.1

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нийт 8626161.0 мянган төгрөгийн орлого тайлагнаж, үүнээс 1289610.8 мянган төгрөгийн давхардсан орлогыг устгасан байна.

Алтайн шим ус ОНӨҮГ-ын 33889.9 мянган төгрөгийн борлуулалтын орлого, 38132.2 мянган төгрөгийн ББӨ-ийн үр дүнд үйл ажиллагааны цэвэр орлого -4,242.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт № 16 Орлогыг төсвийн захирагчдаар ангилж харуулбал:

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Тайлант оны гүйцэтгэл	Устгал	Цэвэр дүн
Орон нутгийн ерөнхий орлого	728,995.7	18,479.1	710,516.6
Орон нутгийн хөгжлийн сан	265,517.0	0.0	265,517.0
Сум хөгжүүлэх сан	1,354.4	0.0	1,354.4
Алтай шим ус	-4,242.3	0.0	-4,242.3
Засаг даргын тамгын газар	2,260,530.2	761,263.5	1,499,266.7
Хүн эмнэлэг	532,017.6	48,030.4	483,987.2
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	59,441.4	57,441.4	2,000.0
Сургууль	4,202,190.1	145,118.4	4,057,071.7
Цэцэрлэг	469,671.0	178,063.5	291,607.6
Соёлын төв	110,685.8	81,214.6	29,471.2
ДҮН	8,626,161.0	1,289,610.8	7,336,550.2

3.5.11 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 327317.5 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар буурчээ.

Хүснэгт № 17 Зардлыг ангилж харуулбал:

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,177,619.2	2,850,301.7	-327,317.5
21	Урсгал зардал	3,177,619.2	2,850,301.7	-327,317.5
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,556,089.9	2,696,640.5	140,550.6
213	Урсгал шилжүүлэг	621,529.3	153,661.2	-467,868.1

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нийт 4139912.5 мянган төгрөгийн зардал тайлагнаж, үүнээс 1289610.8 мянган төгрөгийн давхардсан зардлыг устгасан байна.

Хүснэгт № 18 Зардлыг төсвийн захирагчдаар ангилж харуулбал:

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Тайлант оны гүйцэтгэл	Устгал	Цэвэр дүн
Хо. Ал.Орон нутгийн ерөнхий орлого	728,168.3	713,177.2	14,991.1
Хо. Ал.Орон нутгийн хөгжлийн сан	557,954.6	557,954.6	0.0
Алтай шим ус	450.0	0.0	450.0
Хо. Ал. Засаг даргын тамгын газар	668,259.9	10,019.4	658,240.5
Хо. Ал. Хүн эмнэлэг	506,369.0	1,551.0	504,818.0
Хо. Ал. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	56,975.4	1,161.7	55,813.6
Хо. Ал. Сургууль	1,202,175.5	390.6	1,201,784.9
Хо. Ал. Цэцэрлэг	321,155.8	0.0	321,155.8
Хо. Ал. Соёлын төв	98,404.1	5,356.4	93,047.7
	4,139,912.5	1,289,610.8	2,850,301.7

Аудитын илрүүлэлт:

- ЭМТ: Их эмч нарт ажил хавсран гүйцэтгэсний хөлс болох ЭХО, нярайн үзлэгийн нэмэгдлийг ажлын үзүүлэлт, гүйцэтгэлээр олгоогүй, түүнчлэн ажилтнуудын үр дүнгийн урамшууллыг олгохдоо ажлыг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон.
- ЗДТГ: Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй зөрчлүүд илэрлээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2899546.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2899546.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7022.5 мянган төгрөгөөр бууруулж 2892524.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Алтай сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны 02 дугаар тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн орлого, зардлыг 2899546.7 мянган төгрөгөөр баталсан боловч 7022.5 мянган төгрөгөөр хасагдаж, 2892524.5 мянган төгрөгөөр аймгийн нэгдсэн төсөв төлөвлөгөөнд тусгажээ.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 2892524.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2395732.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 418597.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 78194.5 мянган төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар төлөвлөжээ.

Төсвийн орлого

Алтай сум 2892524.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2571287.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлагдсанаас 321236.8 мянган төгрөг дутуу гүйцэтгэлтэй байна. Үүнд:

Татварын орлогыг 26420.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч татварын бус орлого 217299.6 мянга, тусламж санхүүжилтийн орлого 100478.4 мянга, оны эхний үлдэгдлээс санхүүжих дүн 29878.8 төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй байгаа нь дараах нөхцөлөөс шалтгаалж байна.

- Орон нутгийн ерөнхий орлого, ОНХС, СХС-ийн харилцах дансны үлдэгдлийг орлогын эх үүсвэрт төлөвлөснөөс
- Төсвийн санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлэг

Хүснэгт дугаар 19. Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,892,524.6	2,571,287.8	-321,236.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	63,675.2	90,095.2	26,420.0
110002	Үйл ажиллагааны орлого	1,000.0	5,033.3	4,033.3
110003	Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн орлого	43,507.2	46,525.1	3,017.9
110008	Шууд бус орлого	4,200.0	21,302.4	17,102.4
113002	Бууны албан татвар	3,080.0	2,765.0	-315.0
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,548.0	2,550.7	2.7
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	774.2	274.2
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,420.0	1,426.2	6.2
118101	Газрын төлбөр	0.0	11.1	11.1
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	6,990.0	6,990.0
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6,420.0	937.3	-5,482.7
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,000.0	1,780.0	780.0

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,666,420.8	2,449,121.2	-217,299.6
120	Нийтлэг татварын бус орлого	120,700.8	28,515.2	-92,185.6
120003	Торгуулийн орлого	4,500.0	5,298.1	798.1
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого 41932.8+6405.0+2400.0+65463.0	116,200.8	23,217.1	-92,983.7
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,545,720.0	2,420,606.0	-125,114.0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,656,809.6	1,531,695.7	-125,113.9
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	273,787.0	273,787.0	0.0
123003	Аймгийн төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	615,123.4	615,123.3	-0.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	132,549.8	32,071.4	-100,478.4
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,549.8	32,071.4	-478.4
	Хандив тусламжийн орлого	100,000.0	0.0	-100,000.0
	ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЛЭЭС	29,878.8	0.0	-29,878.8
	Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс	29,878.8	0.0	-29,878.8

Татварын орлого 26420.0 мянган төгрөгөөр давсан нь 2020 онд сумын иргэдийн Эрдэнэс таван толгой хувьцааны ногдол ашгийн татвар 17743.9 мянган төгрөг төвлөрсөн нь гол нөлөө үзүүлжээ.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын 116200.8 мянган төгрөгийн төлөвлөгөөнд сум хөгжүүлэх сан, ОНХС-ийн харилцах дансны оны эхний үлдэгдлээс 65463.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь нөлөөлж байна. Тухайлбал өөрийн орлогын төлөвлөгөө бодитоор 27520.7 мянган төгрөгөөр тасарсан. Өөрийн орлогын төлөвлөгөө тасарсны дийлэнх нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө материаллаг хэмжээгээр буюу 26628.7 мянган төгрөгөөр тасарснаас хамаарчээ.

Хандив тусламжийн 100000.0 мянган төгрөгийн орлого тасарсан шалтгаан нь Ковид-19 вирусны нөхцөл байдлын улмаас Талст молор ХХК үйл ажиллагаа явуулаагүй учир гэрээгээрх 100000.0 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдээгүй, он дамжсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Татварын зарим орлогын ногдуулалт, төлөвлөлт нь бодитоорх тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөгдөөгүй байна. Тухайлбал: Газрын төлбөрийн ногдуулалт 1041.6 мянган төгрөг байхад төсвийн орлого төлөвлөөгүй, Галт зэвсэгтэй иргэдийн судалгаанд үндэслэсэн ногдуулалт 3657.0 мянган төгрөг байхад 3080.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт 2729.8 мянган төгрөг байхад 500.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн байна.
- Хууль бус агнасан ангийн 35680.0 мянган төгрөгийн татварын ногдуулалтаас 6990.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 28690.0 мянган төгрөгийн ангийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн буцаан төлөлтийг 41932.8 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 15304.1 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөснөөс 26628.7 мянган төгрөг дутуу бүрдүүлжээ.
- Сургуулийн спорт заалны 980.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансаар төвлөрүүлээгүй

Төсвийн зарлага

Нийт зардлын 813177.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 273787.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 1656809.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээс, 32549.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 116200.8 мянган төгрөгийг төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төсөвлөснөөс гүйцэтгэлээр ОНХС, ТЗШ-ийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвийн санүүжилтийг 100000.0 мянга, ЭМД-ын сангийн санхүүжилтийг 478.4 мянган төгрөгөөр тус

тус дутуу авч, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг 92983.6 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлжээ.

Хүснэгт №.20. Санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			/мянган төгрөг/ Гүйцэтгэл			Зөрүү
		Санхүүжилт	Өөрийн орлого, оны эхний үлдэгдлээс санхүүжих	Нийт	Санхүүжилт	Өөрийн орлого, оны эхний үлдэгдлээс санхүүжих	Нийт	
1	ЗДТГ	492,886.3	4,405.0	497,291.3	382,866.8	3,880.0	386,746.8	-110,544.5
2	ИТХ	57,441.4		57,441.4	56,279.7		56,279.7	-1,161.7
3	Сум хөгжүүлэх сан		78,194.5	78,194.5		15,304.1	15,304.1	-62,890.4
4	ОНХСан	265,517.0	29,201.3	294,718.3	265,517.0		265,517.0	-29,201.3
5	Соёлын төв	81,214.6	2,000.0	83,214.6	75,858.2	1,633.0	77,491.2	-5,723.4
	ОНБ-ын дүн	897,059.3	113,800.8	1,010,860.1	780,521.7	20,817.1	801,338.8	-209,521.3
6	ЕБСургууль	1,132,827.2	2,400.0	1,135,227.2	1,032,180.7	2,400.0	1,034,580.7	-100,646.5
7	Хүүхдийн цэцэрлэг	305,443.4		305,443.4	282,138.9		282,138.9	-23,304.5
8	Эрүүл мэндийн төв	440,993.8		440,993.8	437,410.9		437,410.9	-3,582.9
	ТЗШ-ийн дүн	1,879,264.4	2,400.0	1,881,664.4	1,751,730.5	2,400.0	1,754,130.5	-127,533.9
	Нийт сумын дүн	2,776,323.7	116,200.8	2,892,524.5	2,532,252.2	23,217.1	2,555,469.3	-337,055.2

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2522265 мянган төгрөг буюу 87.2 хувьтай байгаа нь урсгал зардал 141453.0 мянга, хөрөнгийн зардал 150611.0 мянга, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 78195.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Хүснэгт дугаар 21. Төсвийн зардлыг ангиллаар харуулбал

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,892,525	2,522,265	-370,259
21	Урсгал зардал	2,395,733	2,254,279	-141,453
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,367,283	2,240,482	-126,801
213	Урсгал шилжүүлэг	28,450	13,797	-14,653
22	Хөрөнгийн зардал	418,597	267,986	-150,611
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	78,195	0	-78,195

Хүснэгт дугаар 22. Төсвийн зарлагыг байгууллагаар харуулбал

Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Хо. Ал.Орон нутгийн хөгжлийн сан	294,718.3	247,616.9	-47,101.4
Хо. Ал. Сум хөгжүүлэх сан	78,194.5	0.0	-78,194.5
Хо. Ал. Засаг даргын тамгын газар	497,291.3	386,746.8	-110,544.5
Хо. Ал. Хүн эмнэлэг	440,993.8	437,410.9	-3,582.9
Хо. Ал. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	57,441.4	56,279.7	-1,161.7
Хо. Ал. Сургууль	1,135,227.2	1,034,580.7	-100,646.5
Хо. Ал. Цэцэрлэг	305,443.4	282,138.9	-23,304.5
Хо. Ал. Соёлын төв	83,214.6	77,491.2	-5,723.4
ДҮН	2,892,524.5	2,522,265.1	-370,259.4

Хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээнд нийт 294718.3 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 247616.9 мянган төгрөгийг 11 төсөл арга хэмжээнд зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Алтан гадас багийн төвийн барилга угсралтын ажил, өвс тэжээлийн агуулах барих нийт 309768.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажлаас 5194.3 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутгаагүй олгосон, холбогдох мэргэжлийн боловсон хүчнээр хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 169862.8 мянган төгрөгийн орлогыг доорх эх үүсвэрээс бүрдүүлж, 82286.9 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 70042.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 17533.7 мянган төгрөгийг оны эцэст нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлжээ.

Хүснэгт №.23. Нэмэлт санхүүжилтийн
эх үүсвэр

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант он
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	169,862.8
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,842.6
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,901.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,938.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,179.7

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 151 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 145 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Эрүүл мэндийн төв, сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны мэдээлэл хангалтгүй байсан учир хобогдох албан тушаалтанд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид акт, албан шаардлага бичигдээгүй, 22900.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 80.7%-тай байна.

Хүснэгт 24 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	22900.0	4	22900.0	0	0	80.7%
Нийт	4	22900.0	4	22900.0	0	0	80.7%

Зөвлөмжөөр өгөгдсөн сум хөгжүүлэх сангийн 0.7 сая төгрөгийн үнэтэй программыг ЗДТГ-ын хөрөнгөд орлогод авч, тус сангийн хугацаа хэтэрсэн 12.2 сая төгрөгийн авлага барагдуулах зөвлөмжөөс 10.0 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 2 зөвлөмжийг хангалттай түвшинд биелүүлсэн боловч ЗДТГ-ын анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн хүндэтгэлийн гэр өргөө тохижуулах, нийтийн эзэмшлийн талбайд нарны цахилгаан эх үүсвэртэй гэрэл тавих ажлуудыг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авах талаар өгсөн зөвлөмжийг тухайн онд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №25. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр		Аудитын дүгнэлт		
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	1		1	
2		ИТХ		1		
3		Сургууль	1		1	
4		Цэцэрлэг	1		1	
5		ЭМТ	1			1
6		Соёлын төв	1		1	
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
9	ОӨААНТҮГ	Алтайн шим ус ОНӨҮГ	1		1	
Дүн			6	3	4	2

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн 4 нь зөрчилгүй, 2 нь хязгаарлалттай дүгнэлттэй баталгаажсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 132520.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5194.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 127326.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5+1=6 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар дараах залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Алтан гадас багийн төвийн барилга угсралтын ажил, өвс тэжээлийн агуулах барих нийт

309768.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажлаас 5194.3 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутгаагүй олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, 41.2.7-д “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажлын захиалагчийн дүрэмд тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцагчаар 5194.3 мянга /таван сая нэг зуун ерөн дөрвөн мянга гурван зуун төгрөг/-ийг буцаан төлүүлэх.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид 127326.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Алтай сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 210118.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 12413.4 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 197705.1 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 974.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 182238.8 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, 14492.1 мянган төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт № 26. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

Д/д	Нийт алдаа зөрчил	Нийт алдаа, зөрчил		Үүнээс залруулаагүй							
				Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс залруулсан	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЕБСургууль	4	19,256.6	0	-	0	-	2	7,484.2	2	11,772.4
2	Эрүүл мэндийн төв	8	119,015.9	1	974.2	4	113,058.7	3	4,983.0	0	-
3	Сумын ЗДТГ	4	71,205.0	0	-	2	69,180.1	2	2,024.9		
4	Соёлын төв	5	641.0	0	-	0	-	2	-	3	641.0
Нийт дүн		21	210,118.5	1	974.2	6	182,238.8	9	14,492.1	5	12,413.4

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар тайланд дурдсан болон анхаарах хандуулахуйц асуудлын хэсэгт бичсэн алдаа зөрчилд дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, Алтангадас багийн төвд моторын байр шинээр барих, мотор худалдан авах, бетон зам талбай хийх зэрэг ажлын гэрээ, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, бараа, ажил үйлчилгээ хүлээн авах комиссын акт, хурлын

тэмдэглэл, зураг төсөв, холбогдох бусад баримт бичгүүд нь шаардлагад нийцсэн, иж бүрэн, хүчин төгөлдөр санхүүгийн баримт гэж үзэхэд учир дутагдалтай байна. Түүнчлэн зарим ажил гүйцэтгэх гэрээнд алданги тооцох нөхцөл тусгаагүй байна. /Тухайлбал: Ундрам алт ХХК 19950.0 мянга, Боткон ХХК 1600.0 мянга, Б.Цогбадрах 4800.0 мянган төгрөгийн гэрээ/

4.1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй, хяналтгүй зарцуулагдах, санхүү, төсвийн холбогдох хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавина" гэсэн заалттай нийцүүлж хөрөнгө оруулалтын ажлын гэрээ, акт, холбогдох бусад баримт бичгийг хууль, журам, стандартад нийцүүлэн боловсруулж, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материалын бүрдлийг бүрэн хангаж, архив үүсгэж хэвших.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.2 Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн авлагатай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Өмнөх онуудад ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 14560.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хүндэтгэлийн гэр өргөө тохижуулах, нийтийн эзэмшлийн талбайд нарны цахилгаан эх үүсгүүртэй гэрэлтүүлэг тавих ажлуудыг дутуу хэрэгжүүлж авлагаар тусгасан боловч бүрэн гүйцэтгүүлж хүлээн аваагүй, мөн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 2010 онд олгосон малжуулах сангийн 6 иргэнтэй холбоотой 7200.0 мянган төгрөгийн зээлийн авлага нь он дамжин, насжилт өндөртэй болсон байна.

4.2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй, хяналтгүй зарцуулагдах, санхүү, төсвийн холбогдох хууль тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу "Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцүүлж, ОНХС, СХС-ийн он дамжсан, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, хойшид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын чанар, үр дүнг дээшлүүлэхэд зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.3 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангийн зээлийн буцаан төлөлтийг тайлант онд 41932.8 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 15304.1 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөснөөс 26628.7 мянган төгрөг дутуу бүрдүүлсэн, түүнчлэн сум хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулаагүй, холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх, сум хөгжүүлэх сангийн журам зөрчигдөх эрсдэлтэй

4.3.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн зорилго, үйл ажиллагааны журамд нийцүүлэн сангийн хөрөнгийг удирдан зохион байгуулах. Өөрөөр хэлбэл сангийн хөрөнгийг үйлдвэрлэлийг бий болгох томоохон төсөл хөтөлбөрийг түлхүү дэмжих, зээлийн авлагыг хуваарийн дагуу төсөвт төвлөрүүлэх, зээлийн эргэцийг нэмэгдүүлэх, хугацаа хэтэрсэн

зээлийн авлагыг барагдуулах, зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд холбогдох хяналтыг хэрэгжүүлэх талаар зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.4 Татварын орлогын төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Татварын зарим орлогын ногдуулалт, төлөвлөлт нь бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөгдөөгүй байна. Тухайлбал: Газрын төлбөрийн ногдуулалт 416.6 мянган төгрөг байхад төсвийн орлого төлөвлөөгүй, тайлант онд галт зэвсэгтэй иргэдийн судалгаанд үндэслэсэн ногдуулалт 3657.0 мянган төгрөг байхад 3080.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт 2729.8 мянган төгрөг байхад 500.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн байна. Мөн тайлант онд хууль бусаар агнасан ангийн 35680.0 мянган төгрөгийн татварын ногдуулалтаас 6990.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 28690.0 мянган төгрөгийн ангийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

4.4.2 Эрсдэл: Татвар бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөгдөхгүй, жигд ноогдохгүй, төсвийн орлого бүрдэх боломж алдагдах эрсдэлтэй

4.4.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, удирдамжид нийцүүлэн бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөж болохуйц зарим нэр төрлийн татварын орлогыг түүнд үндэслэн жигд ногдуулахаар төлөвлөх, мөн ногдуулалт хийгдсэн ангийн орлогыг төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.5 Төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, тайлагналтай холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд төсвийн зарим зардлыг нэр төрлөөр оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.

4.5.2 Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

4.5.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу “Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, тус тус нийцүүлэн харьяа байгууллагуудын төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнахад чиглэл өгч, аргазүйгээр хангаж ажиллах. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Алтай сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
2020			ХОА-2021/13/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтай сумын Засаг дарга		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Алтан гадас багийн төвийн барилга угсралтын ажил, өвс тэжээлийн агуулах барих нийт 309768.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажлаас 5194.3 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутгаагүй олгосон, түүнчлэн холбогдох мэргэжлийн боловсон хүчнээр хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	5194.3	Төлбөрийн акт	Засаг дарга, санхүү албаны дарга	Х.Түмэндэлгэр, С.Нэмэхжаргал
2	Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, Алтангадас багийн төвд моторын байр шинээр барих, мотор худалдан авах, бетон зам талбай хийх зэрэг ажлын гэрээ, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, бараа, ажил үйлчилгээ хүлээн авах комиссын акт, хурлын тэмдэглэл, зураг төсөв, холбогдох бусад баримт бичгүүд нь шаардлагад нийцсэн, иж бүрэн, хүчин төгөлдөр санхүүгийн баримт гэж үзэхэд учир дутагдалтай байна. Түүнчлэн зарим ажил гүйцэтгэх гэрээнд алданги тооцох нөхцөл тусгаагүй байна. /Тухайлбал: Ундрам алт ХХК 19950.0 мянга, Боткон ХХК 1600.0 мянга, Б.Цогбадрах 4800.0 мянган төгрөгийн гэрээ/	47024.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүү албаны дарга	Х.Түмэндэлгэр, С.Нэмэхжаргал
3	Өмнөх онуудад ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 14560.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хүндэтгэлийн гэр өргөө тохижуулах, нийтийн эзэмшлийн талбайд нарны цахилгаан эх үүсгүүртэй гэрэлтүүлэг тавих ажлуудыг дутуу хэрэгжүүлж авлагаар тусгасан боловч бүрэн гүйцэтгүүлж хүлээн аваагүй, мөн сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 2010 онд олгосон малжуулах сангийн 6 иргэнтэй холбоотой 7200.0 мянган төгрөгийн зээлийн авлага нь он дамжин, насжилт өндөртэй болсон байна.	21760.0	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүү албаны дарга	Х.Түмэндэлгэр, С.Нэмэхжаргал
4	Сум хөгжүүлэх сангийн зээлийн буцаан төлөлтийг тайлант онд 41932.8 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 15304.1 мянган төгрөгийг бүрдүүлж, төлөвлөснөөс 26628.7 мянган төгрөг дутуу бүрдүүлсэн, түүнчлэн сум хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг	26628.7	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүү албаны дарга	Х.Түмэндэлгэр, С.Нэмэхжаргал

	байгуулаагүй, холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.				
5	Татварын зарим орлогын ногдуулалт, төлөвлөлт нь бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөгдөөгүй байна. Тухайлбал: Газрын төлбөрийн ногдуулалт 416.6 мянган төгрөг байхад төсвийн орлого төлөвлөөгүй, тайлант онд галт зэвсэгтэй иргэдийн судалгаанд үндэслэсэн ногдуулалт 3657.0 мянган төгрөг байхад 3080.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт 2729.8 мянган төгрөг байхад 500.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн байна. Мөн тайлант онд хууль бусаар агнасан ангийн 35680.0 мянган төгрөгийн татварын ногдуулалтаас 6990.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 28690.0 мянган төгрөгийн ангийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.	31913.4	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүү албаны дарга	Х.Түмэндэлгэр, С.Нэмэхжаргал
6	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд төсвийн зарим зардлыг нэр төрлөөр оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга, санхүү албаны дарга	Х.Түмэндэлгэр, С.Нэмэхжаргал
	Дүн	132520.4			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР